



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Х.ГАНЦОГТ ТАНАА

2014.03.06

№ ЧАТ-САТ/2014/01 / СЭГД-ТӨМӨЗ 01/06

Зөрчил арилгах тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сангийн яамны аппаратын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус яамны 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 138.4 сая төгрөгийн хангамжийн бараа материалыг үлдэгдлээр бүртгэж тайлагнасан боловч тооллого хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.
2. Аж ахуйн эд хогшил, нөөцийн бараа материалыг хадгалах зориулалтын агуулах байхгүйгээс нөөцөнд байгаа 4 нэрийн 43.9 сая төгрөгийн хөрөнгө материалыг яамны 8 дугаар давхрын цахим сүлжээний өрөөнд хадгалж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1 “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасныг зөрчиж байна.

ТБОНӨТХуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийх”, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасан заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн дараах Албан шаардлага өгч байна. Үүнд:

1. Хангамжийн бараа материалын тооллогыг 2014 оны 4 дүгээр сарын 01-ний дотор хийж, хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах,
2. Сангийн яамны аж ахуйн бараа материалын агуулахын өрөөг тусад нь гаргаж төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, ерөнхий нягтлан бодогч Б.Тамир нарт тус тус даалгав.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 25-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

АХЛАХ АУДИТОР



Г.ЮРА